

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2019 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
10 ДУГААР САРЫН 25-НЫ ӨДӨР /БААСАН ГАРАГ/-ИЙН НЭГДСЭН
ХУРАЛДААНЫ ТОВЬЁГ**

№	Баримтын агуулга	Хуудас
1.	Хуралдааны товч тэмдэглэл:	1-11
2.	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	12-133
	1.Гаалийн албан татварыг хөнгөлж, буцаан олгох тухай хуулийн төсөл /Засгийн газар 2019.08.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	13-24
	2.Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл /Засгийн газар 2019.08.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	24-28
	3.Онцгой албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл /Засгийн газар 2019.10.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	28-30
	4.Чөлөөт бүсийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2019.10.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	30-47
	5.Төрөөс мөнгөний бодлогын талаар 2020 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монголбанк 2019.09.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	47-93
	6.Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал 2019.02.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	94-112
	7.Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Оюунхорол нарын 10 гишүүн 2019.10.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	112-126
	8.“Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /эцсийн хэлэлцүүлэг/	126-128
	9.“Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	128-129
	10.“Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг, хугацаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	129-133

**Монгол Улсын Их Хурлын 2019 оны намрын ээлжит чуулганы
10 дугаар сарын 25-ны өдөр /Баасан гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 75 гишүүнээс 42 гишүүн ирж, 56.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 28 минутад Төрийн ордны Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны танхимд эхлэв.

Чөлөөтэй: О.Батнасан, Ц.Даваасүрэн, Б.Жавхлан, Ч.Хүрэлбаатар, Н.Цэрэнбат;

Эмнэлгийн чөлөөтэй: Я.Санжмятав, Д.Тэрбишдагва;

Тасалсан: Ж.Мөнхбат, Б.Наранхүү, Ш.Раднаасэд, Д.Сарангэрэл, Ц.Цогзолмаа;

Хоцорсон: Б.Батзориг- 40 минут, Х.Нямбаатар- 10 минут, О.Содбилэг- 2 цаг, Д.Сумъяабазар- 25 минут, Б.Энх-Амгалан- 50 минут, Ж.Энхбаяр- 1 цаг 25 минут, Н.Энхболд- 1 цаг, С.Эрдэнэ- 1 цаг 30 минут.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар энэ долоо хоногт төрсөн өдөр нь тохиож байгаа Улсын Их Хурлын гишүүн Х.Болорчулуун, Д.Эрдэнэбат нарт Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс баяр хүргэж, эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөв.

.....

Арав. “Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг, хугацаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ж.Бямбадулам, зөвлөх А.Солонго нар байлцав.

Тогтоолын төслийн талаар Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Хаянхярваа танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүү, Д.Эрдэнэбат нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан хариулж, тайлбар хийв.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар “Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг, хугацаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг бүхэлд нь батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 29

Татгалзсан: 13

Бүгд: 42

69.0 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар “Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг, хугацаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав.

Тогтоолын эцсийн найруулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүү, Д.Эрдэнэбат нарын тавьсан асуултад, Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа.
/17:56/

Уг асуудлыг 17 цаг 57 минутад хэлэлцэж дуусав.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:
ПРОТОКОЛЫН АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2019 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
10 ДУГААР САРЫН 25-НЫ ӨДӨР /БААСАН ГАРАГ/-ИЙН НЭГДСЭН
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүдийн өдрийн амгаланг айлтгая.

Гишүүдийн ирц бүрдсэн байна. Улсын Их Хурлын 2019 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сарын 25-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

.....

Дараагийн асуудалд орно. Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ. Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Дамдины Хаянхярваа танилцуулна. Хаянхярваа гишүүнийг индэрт урьж байна аа.

Д.Хаянхярваа: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ.

Улсын Их Хурлын 2019 оны 9 дүгээр сарын 11-ний өдөр баталсан “Ард нийтийн санал асуулга явуулах, Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн эхийг батлах тухай” 73 дугаар тогтоолд бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг Улсын Их Хурал 2019 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцэн хоригийг хүлээн авсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.8, 31.9 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн Төрийн байгуулалтын байнгын хорооноос “Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” Улсын ИХ Хурлын тогтоолын төслийг боловсруулж 2019 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх явцад Улсын Их Хурлын гишүүн Д.Эрдэнбат Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авсантай холбогдуулан 73 дугаар тогтоол хүчингүй болж байгаа нь Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн 2 дахь хэлэлцүүлэг бүхэлдээ хүчингүй болж байгаа эсэх талаар асуулт асуухад Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Д.Лүндээжанцан нар хоригийг хүлээж авснаар Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай тухай хуульд заасны дагуу Улсын Их Хурал төслийг Ард нийтийн санал асуулгад оруулах нь зүйтэй гэж тогтсон хүртэлх процесс буюу Ард нийтийн санал асуулгад оруулах төслийн нэг, хоёр дахь хэлэлцүүлэг хэлэлцүүлэг хүчингүй болно. Харин Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний гурваас доошгүйн дэмжлэг авсан нэг, хоёр дахь хэлэлцүүлгээр санал хурааж шийдвэрлэсэн төсөл хэвээрээ үлдэх талаар тайлбар хийв.

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 14.5-д төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг, хугацааг тогтоосон Улсын Их Хурлын тогтоолыг баталж, төслийг Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлж, энэ тухай нийтэд зарлан мэдээлнэ гэж заасан.

Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь “Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” Улсын Их Хурлын тогтоолын

төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулж, батлуулах нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ. “Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, тогтоолын төслийг баталж өгөхийг Та бүхнээс хүсье. Анхаарал тавьсан явдалд баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу. Алга байна.

Байнгын хорооны саналаар “Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна аа.

75 хувиар тогтоолын төсөл батлагдлаа. Тогтоолыг уншиж танилцуулъя.

“Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.8 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас Тогтоох нь:

1.Ард нийтийн санал асуулга явуулах “Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн эхийг батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2019 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн 73 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

2.Энэ тогтоолыг 2019 оны 10 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Дараагийн асуудалд орно.

“Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг 3 дахь хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг, хугацааг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ ээ.

Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Дамдины Хаянхярваа танилцуулна. Хаянхярваа гишүүнийг индэрт урьж байна аа.

Д.Хаянхярваа: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ. Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т заасны дагуу Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсвийн хоёр дахь хэлэлцүүлгийг хийж дууссаны дараа Улсын Их Хурал төслийг Ард нийтийн санал асуулгад оруулж батлуулах нь зүйтэй гэж тогтож, “Ард нийтийн санал асуулга явуулах, Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн эхийг батлах тухай” Улсын Их Хурлын 73 дугаар тогтоолыг баталсан. Энэхүү тогтоолд Ерөнхийлөгч хориг тавьсныг Улсын Их Хурал 2019 оны 10 дугаар сарын 04-ний өдөр хүлээн авсан тул Төрийн байгуулалтын байнгын хороо, “Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг гурав дахь хэлэлцүүлэгт

бэлтгэх үүрэг, хугацааг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, 2019 оны 10 дугаар сарн 23-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Уг тогтоолын төсөлд Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх хугацааг 2019 оны 10 дугаар сарын 25-наас 2019 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийг хүртэл тогтоож, энэ хугацаанд төслийн талаар иргэдэд мэдээлж, тайлбарлан таниулахыг Улсын Их Хурлын нийт гишүүнд даалгахаар тусгасан болно.

“Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг, хугацааг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулж батлуулахыг хуралдаанд оролцсон гишүүд санал нэгтгэйгээр дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ. “Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг, хугацааг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталж өгөхийг Та бүхнээс хүсье. Анхаарал тавьсан явдалд баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу. Алга байна. Эрдэнэбат, Баасанхүү 2 гишүүнээр тасаллаа. Октябрийн Баасанхүү гишүүн асуулт асууна. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулна.

О.Баасанхүү: Би 1 зүйл асуумаар байгаа юм. Энэ Үндсэн хуулийг хэлэлцэхэд тасралтгүй бөгөөд дундуур нь ямар нэгэн хууль оруулж батлахгүй ээ гэсэн. Тухайн үед анхны хэлэлцүүлэг явах үед хугацаатай байгаа жишээлбэл Төсвийн тухай хууль ч гэдэг юм уу, Мөнгөний бодлогын тухай хууль ч гэдэг юм уу. Энэ хуулиудыг хэлэлцэхэд яах вэ гэхээр за хугацаатай, тодорхой хугацаатай болбол дэг зөрчихгүй ээ гээд явж байсан. Гэтэл одоо гурав дахь хэлэлцүүлгээ хийх тухай дэгийн гээд ингээд ороод ирэх юм. Миний ойлгож байгаагаар Үндсэн хуулийн хэлэлцүүлэг гэдэг бол 1, 2, 3 эсхүл 1, 2, 3, 4 гэсэн ийм дарааллаар явдаг гэж би ойлгоод байгаа юм. Нэгээ хийчихсэн гэж ойлгоё, хоёроо хийчихсэн гэж ойлгоё. Гурваа болбол за Ард нийтийн санал асуулга явахгүй гэвэл шууд одоо батлаад явах ёстой. Хэрвээ Ард нийтийн санал асуулга явна аа гэх юм болбол гурвын үр дүнг харж байгаад 4-ийг хийх үү, үгүй юу гэдгээ шийднэ. Ийм л байгаа шүү дээ.

Гэтэл өнөөдөр ерөөсөө хөл толгойгоо олохгүй, одоо манай энэ ард түмэн чинь юуг гайхаад байгаа гэвэл нөгөө Үндсэн хууль гэдэг сэдэв дуусчихсан юм байна аа. Би маш олон хүнээс асуусан. Би чинь өөрөө бас Эрдэнэтээс сонгогдсон учраас хотын статус энээ тэрээ гэдэг нь чухал гэдэг утгаараа Үндсэн хуулийн өөрчлөлтийн 62-ын нэг болоод явсан чинь өнөөдөр зүгээр л бид дураараа аашилдаг, бүх юмыг хуульд нийцүүлж ажиллах ёстой байтал бид өөрсдөө хууль гээд ойлгочихсон. Ингээд дураараа яваад байдаг. Гэхдээ үүнийг бол дараагийн 20 оныхон ч гэдэг юм уу, 24 оныхон ч гэдэг юм уу, энэ түүхээрээ үлдээд бүр бидний шившгийг сонсоод хачин болно л доо. Тэгэхээр энэ дэгийг оруулснаар зүгээр л Ерөнхийлөгчид таалагдах гэсэн нэг юмыг оруулж байна гэж би хараад байна шүү дээ. Өөрөөр хэлэхийн бол 3 хоног байх уу, 30 хоног байх уу гэдгийг л оруулах хувилбар яриад байна гэж би ойлгоод байна. Энэ хуулийн заалтыг би тэгж ойлгосон. Тэгэхээр энэ юу вэ гэвэл нэгэнт хууль юм бол тэгээд хуулиа батлаад

яваач дээ. Гурав гээд тавьсан бол одоо алх цохьсон бол гурав. Гуч гэсэн бол гуч. 3 жил гэсэн бол 3 жил. Хууль бол зөвхөн үндэслэлээр буюу шалтгаанаар байдаг болохоос биш өө, би андуурчхаж. Биднийг өнөөдөр ЖДҮ-дчихсэн учраас оруулж ирэх гээд байгаа юм. Саарал жагсаалтаар биднийг одоо сэлэмдэх гээд байгаа юм гээд тал тал руу ингэж ороод өнөөдөр, жишээлбэл одоо ийм байдлаар хуулийг өөрчилж болохгүй ээ. Оюунхорол гишүүн ээ би тантай холбоотой юм яриагүй байна. Би тантай холбоотой юм яриагүй байна. Та бол хулгайч хүн.

Г.Занданшатар: Үндсэн асуудлаа ярихгүй, бусад руугаа тэгж дайрч болохгүй ээ. Дондогдоржийн Эрдэнэбат асуулт асууна.

Д.Эрдэнэбат: Одоо энэ хоригийг хүлээж аваад, тогтоолыг цуцалснаар 2 зүйл цуцлагдаж байна гэж би ойлгож байгаа л даа. Нэгдүгээрт, Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хоёрдугаар хэлэлцүүлгээр баталсан эхийг одоо цуцлаад дахин хэлэлцэх боломж нээж байна аа гэж би хараад байгаа юм. Би Байнгын хороон дээр энэ байр сууриа илэрхийлсэн юм. Бид нар энэ 2 дугаар эхийг, энэ тогтоолыг цуцалснаараа 2 дугаар хэлэлцүүлгийг эргэн хэлэлцэх ийм хаалга нээгдэж байгаа юм биш үү гэхэд манай гишүүд, Тамгын газар үгүй ээ гээд тайлбарлаад байгаа юм. Би тэгээд энэ нь маргаан үүсгээд дараа нь Цэц дээр оччих вийдээ.

Цэцийн маргаан болоод энэ одоо эх нь батлагдсан эх цуцлагдсан байхад шууд гурав дугаар хэлэлцүүлэг рүү орлоо гэж ингэж ойлголт үүсээд дараа нь гурав дугаар хэлэлцүүлгээрээ батлагдсаны дараа энэ хууль чинь зогсчих юм биш үү гэж би асууж байгаа юм. Тийм учраас албан ёсны тайлбар заавал авах шаардлагатай байна аа гэж илэрхийлсэн. Тийм учраас энэ дээр дахиж нэг тодотгол хийгээд хууль эрх зүйн хувьд нь заавал би асууж байгаа юм аа. Энэ бол протоколд тусах ёстой зүйл. Дараа нь маргаан гарах юм бол эрх зүйн хувьд ямар хамгаалалтыг энэ холбогдох Байнгын хорооны Тамгын газрынхан нь, хууль санаачилсан улсууд хийсэн бэ гэдэг дээр тайлбар эргэж нэхэгдэнэ ээ.

Энэ дээр нэгдүгээрт дахин тайлбар өгөөч. Хоёрдугаарт, одоо энэ тогтоол батлагдсанаар Ард нийтийн санал асуулга байхгүй боллоо гэж ойлгож болох уу. Одоо бол ард түмнээс Ард нийтээрээ санал асуухаа больлоо. Одоо шууд гуравдугаар хэлэлцүүлэг рүүгээ оръё оо. Тийм учраас ард түмэн та нар минь тайван бай гэж хэлж болох уу. Энэ дээр яг надад эцсийн ард нийтэд ойлгомжтой энэ тайлбар хэрэгтэй байна аа. Тэгэхгүй бол өнөөдөр бид нар өнгөцхөн яриад нэг тогтоол баталсан гээд чимээгүй хаачхаад дараа нь дахиад Ард нийтийн санал асуулга явна, явуулахгүй, гурав дугаар хэлэлцүүлэг хийнэ, хийхгүй гэдэг маргааныг бид нар дахиж хийж болохгүй ээ. Тийм учраас ард нийтэд нэгдсэн ойлголт өгөхийн тулд үүнийг эцсийн цэг тавих хариултыг надад өгөөч ээ гэж би ингэж хүсэж байна аа. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: За, Лүндээжанцан дарга асуултад хариулна.

Д.Лүндээжанцан: За, би Эрдэнэбат гишүүний энэ болгоомжлолд хариулт өгөх ёстой юм аа. Манай Төрийн байгуулалтын байнгын хороон дээр Байнгын хорооны дарга болон Тамгын газраас тайлбар өгсөн. Лавлагаа өгсөн. Улсын Их Хурал Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг хийж дуусгасан. Цөмөөрөө мэдэж байгаа. Бүх асуудлыг 57 гишүүнээс дээш дэмжиж, энэ асуудлыг хийсэн. За, Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 17.1-д Улсын Их Хурал төслийн 2 дахь хэлэлцүүлгийг хийж дуусгаад

тухайн нэмэлт, өөрчлөлтийг Ард нийтийн санал асуулгаар батлах уу, гурав дахь хэлэлцүүлгээр батлах уу гэдгээ Ард нийтийн санал асуулгаар батална гэвэл гуравны хоёроос дээшхийн саналаар батлах ёстой. За ингээд хуралдаад гуравны хоёроос дээшхи нь Ард нийтийн санал асуулгад оруулах нь зүйтэй гэж үзсэн.

Дараагаар нь Ард нийтийн санал асуулга явуулах болоод үүний дагуу хоёр дугаар хэлэлцүүлгийн үр дүнд гарсан төсөл дээр Ард нийтийн санал асуулгад оруулах тухай 1, 2 дугаар хэлэлцүүлгийг хийгээд, 2 үндсэн санал гүйцээж боловсруулахаар гаргасан 6 найруулгын шинжтэй засвар хийгээд эхийг баталсан. Сая эх хүчингүй боллоо. Эх хүчингүй болохоор Ард нийтээс санал асуулгад оруулах, эх хүчингүй болохоор нийтдээ хүчингүй болох уу гэдэг асуудал яриад байгаа юм аа. Тийм зүйл бол байхгүй ээ. Хоёрдугаар хэлэлцүүлгийн дараа 2 зам байна аа бидэнд. Ард нийтийн санал асуулгад оруулах уу эсвэл гурав дугаар хэлэлцүүлэгт оруулах уу гэдэг 2 зам байсан. Эхнийхээр нь бол яваад Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авсан учраас энэ тогтоолыг дөнгөж сая хэдхэн минутын өмнө баталлаа.

Өөрөөр хэлбэл тэр хориг хууль гэдэг нэртэй орж ирсэн. Үндсэн агуулгаар бол бид хориг тавиагүй ээ гэж ярьсан шүү дээ. Харин тэр хууль хэдэн нэмэлт, өөрчлөлт гэдэг нэрээр орж ирсэн хууль гэдэг нэрээр орж ирээгүй. Хоёрт нь Ард нийтийн санал асуулгын тухай хуулийн зохих заалтыг ишлэл аваагүй гэдэг хоёр үндэслэлээр хориг тавигдсан байгаа. Тэгээд ингээд аваад, Ард нийтийн санал асуулга нь одоо ингээд зогсоод хүчингүй болчхож байгаа учраас гурав дугаар хэлэлцүүлэг рүү орох зай үлдэж байгаа юм аа. Үүнтэй холбогдуулаад Ард нийтийн санал асуулгад оруулах эхэд орсон нөгөө хоёрдугаар хэлэлцүүлгээр орж ирсэн 2 нэмэлт санал, мөн 6 найруулгын санал бол хүчингүй болж байна аа. Үүнтэй холбогдуулаад гурав дугаар хэлэлцүүлэгт бэлтгэхдээ Энхтүвшин даргаар ахлуулсан ажлын хэсэгт сая үүрэг өгсөн байгаа. Энэ саналуудыг дахиж санал хураах, гуравдугаар хэлэлцүүлэг дээр дахиж санал хураах шаардлага гарч байна аа. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын хуулиар дөрөв дэхь хэлэлцүүлэг гэж байхгүй ээ. Гурав дахь хэлэлцүүлгээр зүйл хэсэг бүрээр санал хураагаад хамгийн сүүлд нь бүхэлд нь батлах эсэхээр санал хураана аа гэж ингэж заасан байна аа.

Бид журмынхаа хуулийг бас сайн унших шаардлагатай байгаа юм. Ийм учраас бид бүхэн бол байна шүү дээ, нэг, хоёрдугаар хэлэлцүүлэг одоо үндсэн нэг, хоёрдугаар хэлэлцүүлэг үндсээрээ хүчингүй болж байгаа хэрэг биш ээ гэж одоо манай Тамгын газар болоод Үндсэн хуулийн журмын хуулийг уншиж үзэхээр ийм ямар ч байсан гаргалгаа бол бүрэн байна аа. Энэ нотолгоотой зүйл ээ гэдгийг хэлье ээ. Бид бүхэн бол манай гишүүд цөмөөрөө сайн мэдэж байгаа. Нэгдүгээр хэлэлцүүлгээ хийлээ. Тэр нь бол асуулт хариултаар саналуудаа хэлээд явлаа. Хоёрдугаар хэлэлцүүлгээрээ бүгд санал хураалт явагдлаа. За одоо яах вэ гэсэн чинь Ард нийтийн санал асуулга гэдэг замыг нь сонгоё оо гэсэнэ. Тэр нь бүтэхгүй байгаа учраас гуравдугаар хэлэлцүүлэг рүү орно. За, мөн хэлэлцүүлэг тус бүрийн хооронд ажлын

Г.Занданшатар: За гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. За санал хураалт явуулъя.

Тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулна.

69 хувиар тогтоолын төсөл батлагдлаа. Тогтоолын эцсийн найруулгыг уншиж танилцуулъя.

“Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг, хугацааг тогтоох тухай” Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны тэгийн тухай хуулийн 24⁴ дүгээр зүйлийн 24⁴.12 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас Тогтоох нь:

1.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх хугацааг 2019 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийг хүртэл тогтоож, гурав дахь хэлэлцүүлгийг хийх бэлтгэл ажлыг хангахыг Монгол Улсын Их Хурлын 2019 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн 68 дугаар тогтоолоор байгуулагдсан ажлын хэсэг Ө.Энхтүвшин, Төрийн байгуулалтын байнгын хороо С.Бямбацогт, Улсын Их Хурлын Тамгын газар Л.Өлзийсайханд тус тус даалгасугай.

2.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн талаар иргэдэд мэдээлж, тайлбарлан таниулахыг Улсын Их Хурлын нийт гишүүнд даалгасугай.

3.Энэ тогтоолыг 2019 оны 10 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Эцсийн найруулгатай холбоотой саналтай гишүүн байна уу. Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлж байна аа.

Ард иргэддээ мэдээлэхийг, тайлбарлан таниулахыг даалгасугай гээд энэ Улсын Их Хурлын нийт гишүүдэд даалгасан тогтоолын төсөл уншсан.

За, дараагийн асуудалд орно.

Давс иоджуулж иод дутагдлаас сэргийлэх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ч.Улаан танилцуулна аа. Улаан сайдыг индэрт урьж байна аа.

За ингээд. За асуудал хэлэлцэхгүй юм байна аа. Улсын Их Хурлын Тамгын газраас, өөр асуудал хэлэлцэхгүй юу одоо. Хүчингүй болсонд тооцох хууль учраас дараа явуулъя.

За ингээд өнөөдрийн хэлэлцэх асуудал хэлэлцэж дууслаа. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн гурав дахь хэлэлцүүлэг эхлүүлэхээр тогтоолын төслөөр шийдвэрлэсэн учраас өөр асуудал өнөөдөр хэлэлцэхгүй ээ.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье ээ.

Дууны бичлэгээс буулгасан:
ПРОТОКОЛЫН АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ